

**МОНГОЛ ТӨМС” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл		
1	Төслийн нэр		“Монгол төмс” хөтөлбөр		
2	Төслийн дугаар		7F-03747.02		
3	Санхүүжүүлэгч байгууллага		Швейцарийн хөгжлийн агентлаг		
4	Хөтөлбөр хэрэгжүүлж буй хугацаа		2009 – 2011 он		
5	Хөтөлбөрийн зорилго		Монголын төмсний салбарын бүтээмжийг сайжруулах замаар хэрэглэгчдийг дотоодын үйлдвэрлэлийн эрүүл, тэжээллэг хүнсний төмсөөр хангах, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах.		
6	Хөтөлбөрийн зорилтууд		<ol style="list-style-type: none"> 1. Үр үржүүлэг, үрийн хангалтын системийг хөгжүүлэх. 2. Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах. 3. Хүнсний тэжээллэг чанарыг сайжруулж, борлуулалтын сүлжээг боловсронгуй болгох. 4. Бүх түвшинд чадавхийг бэхжүүлэх. 		
7	Төслийн үр шим хүртэгчид		<ul style="list-style-type: none"> • Эрдэм шинжилгээний байгууллагууд • Лицензтэй албан үр үржүүлэгчид • Албан бус үр үржүүлэгчид • Хүнсний төмс тариалагч иргэн, ААН болон өрхийн тариалан эрхлэгчид 		
8	Зардал /2008-2011/	Төсөв/нийт шаардагдах зардал/	3872000.00 CHF		
		Тухайн жилд төсөвлөсөн	1310895,95 CHF		
		Гүйцэтгэл /тухайн жилд/	963471.84 CHF		
		Үүнд:	Зардлын нэр	Үнийн дүн /CHF/	Төсөв зарцуулалт
		1. <u>Бүрэлдэхүүн хэсэг1:</u> Үр ба шинэ сорт	424,5мян.chf	365.3 мян.chf	
		2. <u>Бүрэлдэхүүн хэсэг2:</u> Үйлдвэрлэлийн аргыг сайжруулах	183,6мян.chf	94.4 мзн.chf	
		3. <u>Бүрэлдэхүүн хэсэг3:</u> Борлуулалтын сүлжээг сайжруулах	77,9 мян.chf	117,0мян.chf	
		4. <u>Бүрэлдэхүүн хэсэг4:</u> Зохистой бодлого, нөхцөл	140,7 мян.chf	103,2 мян.chf	
		5. Менежментийн Зардал	322,3 мян.chf	283,4 мян.chf	
		6. Нийт: - хойшилсон санхүүжилт	1310,9мян.chf 963,5 мян.chf	963.5 мян.chf	
		Бодит санхүүжилт	258,2 мян.chf	1052,7мян.chf	
				91.5%	

	Санхүүгийн талаар:		Тайлангаас харахад: Төсөв 2008 оныхоос 19,8%-иар, зарцуулалт 1,2 дахин тус тус нэмэгдсэн нь төслөөс хэрэгжүүлэх арга хэмжээг бодитой төлөвлөж, зарцуулсныг харуулж байна. Нийт зардлын 37,9%-ийг үрийн аж ахуйг хөгжүүлэх, шинэ сортыг үйлдвэрлэх, үрийг шинэчлэх, албан болон АБҮҮ-чдийн үйл ажиллагааг дэмжихэд, 29,4%-ийг МТХөтөлбөрийн менежментийг сайжруулахад, 10,7%-ийг төмсний үйлдвэрлэлийн бодлогыг сайжруулах, фермерүүдэд эргэлтийн сангаас үйл ажиллагааг нь тогтворжуулах, бодит орлоготой болгоход нь хөнгөлттэй зээлд хамруулж, дэмжлэг үзүүлэхэд тус тус зарцуулсан байна. Иймд төсвийг үр ашиггүй зүйлд зарцуулаагүй, хандлага зөв тал руугаа явж байгааг илтгэж байна.				
9	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлт % 81,4% II шатны зорилт, арга хэмжээ	Дүн	80,7	84,0	82,5	78,3
			4	1	1	1	1
10	Хөтөлбөрийн хэрэгжилт		2008 оны хэрэгжилт-83.6%				
1. Үр үржүүлэг, үрийн хангалтын системийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:							
	- Үр дүн 1.1 Лабораториудын өвчлөлгүй бэсрэг булцуу үйлдвэрлэлийн өртөг буурна.		<p>Үр дүн 1.1-ийн хүрээнд: ЭШХ-үүдийн эрүүл үрийн материал үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлсний үр дүнд 114,8 мян.ш бичил булцуу үйлдвэрлэснээс гэрээний дагуу Импала сортын-70,2 мян.ш, Витара-44,6 мян.ш, нийт- 114,8 мян.ш-ийг вирусээс эрүүлжигдсэн бэсрэг булцуу үйлдвэрлэсэн бөгөөд 12мян.ш-ийг аэропоник системд үйлдвэрлэжээ. Өмнөх онтой харьцуулбал 2009 онд бэсрэг булцуу үйлдвэрлэх аэропоник системийг 1 сараар илүү хугацаанд ажиллуулсан. Мөн ЭШХ-үүд хүлэмжийн нийлэг хальсан хучлагаа торон хучлагаар сольсноор температурыг тохируулж, дээрх булцууны ургацыг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ. Гэвч 2009 онд 200,0 мян.ш булцуу үйлдвэрлэх зорилт тавьж ажилласан боловч биелэлт 57,4%-тай байна. МТХ-өөс 2 судлаач, 1 байцаагчийг вирусийн оношлогоо, шинжилгээний чиглэлээр богино хугацааны сургалтанд хамруулснаар эдгээр мэргэжилтнүүд вирусийг эрт шатанд нь оношлох боломжтой болсон. ЭШХ-үүдийн чадавхийг сайжруулж аэропоник систем суурилуулснаар вирусээс эрүүлжигдсэн бэсрэг булцууны үржлийн илтгүүрийг нэмэгдүүлж, өөрийн өртгийг 250төг-өөс 69 төг болгож бууруулж чадсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-73,7%</p>				
	- Үр дүн 1.2 Үрийн доройтлын судалгаан дээр үндэслэн чанартай үрийг шаардлагатай газар нь хүрэлцээтэй хэмжээгээр, үр ашигтай үйлдвэрлэх асуудлыг шийдвэрлэнэ.		<p>Үр дүн 1.2-ын хүрээнд: АҮҮ-дийн үр үржүүлгийн талбайд үрийн мэргэжилтнүүд газар дээр нь технологийн зөвлөгөө өгч ажилласны үр дүнд үр үржүүлгийн технологи мөрдөлт сайжирч үрийн чанар дээшлэн сорт хамгаалахад дөхөм болж байна. Хөтөлбөрийн үржүүлж буй 4 сортыг 4440,2 га-д хүрч нийт тариалах талбайн 39%, шинээр нутагшуулсан 3 сортынх 1200 га-д хүрч тариалах талбайн 10%-д хүрчээ. 2009 онд сортын талбайд хийсэн хянан баталгаа нь 2008 оныхоос 80,2%-иар</p>				

<p>-Үр дүн 1.3 Албан бус үр үржүүлэгчдийн тогтвортой, чанартай үр үйлдвэрлэл явуулах хүчин чадал нь нэмэгдэнэ.</p>	<p>нэмэгдэж 334,3 га талбайг хамарчээ. Үүнээс: 30% нь чанарын 1-р категорит, 37% нь 2-р категорит, 28% нь 3-р категорит, 3,8% нь өвчний халдвараар сортын тариаланд тэнцээгүй байна. Импала сортын 374 тн элит, витара-150 тн, санте-700 гаруй тн 1-р репродукцийн үрийн нөөц бүрдүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-80%</p> <p>Үр дүн 1.3-ын хүрээнд: АБҮҮ-чид, үр шинэчлэлийн хөтөлбөрт хамрагдсан фермерүүдийн үрийн технологи мөрдөхөд нь зориулж 12 гнэр төрлийн багаж, төхөөрөмжүүд, ургамал хамгааллын бодис, 60 тн бордоог нийлүүлж дэмжлэг үзүүлсэн. Мөн 510 тн-ын багтаамжтай 28ш шинэ зоорь барихад зориулж 28,0 сая.төг, 140 тн-ын 6 зоорийг сэргээн засварлахад 5,0 сая.төг, 3 худаг гаргахад 24,8 сая.төг, төмсний зориулал тын техник худалдан авахад 54,0 сая.төг-ийн дэмжлэг үзүүлжээ. 2009 онд шинээр 75 фермерийг АБҮҮ-ээр сонгож, 103 тн үрийг үрийн шинэчлэлд нь зориулан олгож, 287 фермерийг үр шинэчлэлийн хөтөлбөрт хамруулж 180 тн үр олгосон байна. МТХ-өөс витара, импала, куарта сортын 75 тн дээд үржүүлгийн үрийг 5 ААН, иргэдтэй гэрээ байгуулж, технологийн удирдлага, хяналтын дор үржүүлснээр 549,8 тн элит үртэй болов. Үрийн дундаж ургац-16,7-40,0тн/га байв. Тайлант онд 21 аймгаас 75 АБҮҮ, 287 үр шинэчлэгч фермерийг шинээр сонгосон. МТХ шинээр сонгогдсон үр үржүүлэгчид, фермерүүдэд 180 тн үрийн төмсийг олгосон. Төмс тариалагч фермерүүд, хашаандаа ногоо тарьдаг иргэд орон нутгаасаа чанартай үрийн төмс худалдан авах боломжтой болж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-85%</p>
<p>-Үр дүн 1.4 Жижиг фермерүүдийг чанартай үрээр хангах механизм, үрийг үр ашигтай хэрэглэх стратегийг түншүүдийн хамт илрүүлж олно.</p>	<p>Үр дүн 1.4-ын хүрээнд: Шинэ сортуудыг тариалсан талбай-1250.0 га болсноос импала-378.1 га, витара-175.6, санте-696.3 га-д тариалсан нь улсын хэмжээнд төмс тариалсан талбайн 10%-ийг эзэлж байна. Улаанбаатар хот болон орон нутаг нийт 200 гаруй сумын жижиг хэмжээний төмс тариалагч фермерүүд, өрхийн тариалан эрхлэгчид шинэ сортуудын төмсний үр тариалсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-80%</p>
<p>-Үр дүн 1.5 Сорт сорилт, судалгаа</p>	<p>Үр дүн 1.5-ын хүрээнд: 2009 онд Улсын сорт сорилтын зөвлөлийн шийдвэрээр санте сортыг “Нутагшсан сорт”-оор батлуулж, гала, миранда сортуудыг “Ирээдүйтэй сорт”-оор бүртгүүлж, маделайне, курола, зафира, провенто, синора, артемис, куарта, винета сортуудыг улсын сорилтонд албан ёсоор оруулжээ. Говийн бүсэд сорт сорилтын салбар нэгж үүсгэн байгуулж, Өмнөговь аймгийн ХХААЖДҮГ-ын дэргэд гадаадын 10 сортоор туршлага тавьсан. Үүнтэй холбоотойгоор гадаадын болон дотоодын оюутны дадлагын ажлын хүрээнд сорт сорилтын арга зүйг боловсруулан баталж, талбайн туршилт судалгааны ажлыг эхлүүлжээ. Монголд албан ёсоор төмсний 21 сорт соригдож байгаагаас 16 нь МТХ-ийн туршилт үзүүлэнгийн талбайд соригдож байна. 2 аймгийн 2 экстейншний төвд соригдож байгаа 5 сортын</p>

		төмс тухайн орон нутгийнхаа хүнсний болон үрийн төмсний үржүүлэгт ашиглагдана. Хэрэгжилт- 85%
	Үр дүн1-ийн хэрэгжилт:80,7% (73,7+80+85+80+85)/5	
	2.Үйлдвэрлэлийн аргыг сайжруулах зорилтын хүрээнд:	
<p>Үр дүн.2.1.Оролцооны арга дээр түшиглэн зорилтот бүлэг тус бүрийн онцлогт тохирсон илүү үр ашигтай, тотвортой үйлдвэрлэлийн аргуудыг нэвтрүүлнэ.</p> <p>Үр дүн.2.2.Ирээдүйтэй, байгаль орчинд ээлтэй технологийг өргөн хүрээнд дэлгэрүүлнэ.</p>	<p>Үр дүн 2.1.-ийн хүрээнд: УХЭШХ-тэй хамтран шинээр Титус, Зонтран гэсэн 2 төрлийн гербицидийг талбайн туршилтад оруулан, техникийн үр дүнг хээрийн туршлага болон аж ахуйн нөхцөлд харьцуулан тооцжээ.Эдгээр гербицид нь ургалтын хугацааны дунд үе хүртэлх хугацаанд хэрэглэх боломжтойгоороо өмнө нь хамгийн түгээмэл хэрэглэж байсан грамоксоноос давуу талтай юм. Туршилтыг Агро-Альфа ХХК-ийн төмсний талбайн ургац 1га-гаас 286,7-432,0 цн байгаа нь гербицид хэрэглээгүй хяналттай харьцуулахад 2,76-54,84%-иар илүү ургацтай байв.Уг гербицид 2010 онд импортлох зөвшөөрөлтэй химийн бодисын жагсаалтад албан ёсоор бүртгэгдэх юм байна. Төмсний вирус тараагч шавьжийн төрөл зүйлийг тогтоох судалгаа хийснээр хамгийн аюултай хортон болох тоорын ногоон бөөсний тархалт, өсөлт үржлийн судалгааг Сэлэнгэ аймгийн Мандал, Төв аймгийн Борнуур сумдад хийжээ. Утсан өт нь төмсний таримлыг 12-45%, булцууг 1,2-1,5%-иар, бүгэг эрвээхэйн хүрэнцэр 2-11% ба, 2,0-2,6%-иар тус тус гэмтээж байна. Эдгээр хортны гэмтлээс шалтгаалж ургацын алдагдал 69,9-37,2ц/га байв. Дээрх хортны эсрэг Актара инсектицидийг хөрсөнд тарихын өмнө хийх ба ургалтын хугацаанд шүршихэд 90-95%-ийн, харин карате инсектицид 75-77,5%-ийн техникийн үр дүнг үзүүлж, ургац 3,0-8,0 тн/га –аар өссөн. Вирусээс эрүүлжигдсэн төмсний бэсрэг булцуу үйлдвэрлэхэд вермикулитийг ашиглах, тусгай найрлагатай наалдуулагч шавьж баригч ашиглан 3 төрлийн бөөсний тархалтыг хянах туршилт, био-горон хүлэмжинд бэсрэг булцуу үйлдвэрлэх зэрэг туршилтуудыг хийж, үр дүнг нь тооцжээ. Хэрэгжилт-82%</p> <p>Үр дүн 2.2.-ын хүрээнд: Органик төмсний үйлдвэрлэлийн технологи боловсруулах судалгааг 4 газарт судлаачид болон фермерүүдийнг оролцуулж явуулсан.ОХУ-ын бактофит, битоксициллин зэрэг биопестицидийг байгалийн гаралтай бусад бордоо, сөслт идэвхжүүлэгч бэлдмэлүүдийн хамт хэрэглэснээр өвчин, хортны хор хөнөөлөөс ургамлаа хамгаалах, мөн ямар нэгэн химийн бодисын үлдэгдэлгүй эрүүл цэвэр органик төмс хураан авах боломжтойг тогтоожээ. Бэлдмэлүүдийн техник үр дүн нь химийн пестицидийн дүнтэй ижил түвшинд байж, ургац нэмэгдүүлэх боломжтой гэдэг нь туршилтаар батлагдсан. МТХ нь “Зүүн Азийн хуурай сэрүүн бүс нутагт төмсний таримлыг тариалах арга” сэдэвт олон улсын семинар, “Төмсний салбарын хөгжил дэвшил ба цаашдын чиг хандлага” эрдэм шинжилгээний бага хурал зэрэг арга хэмжээг зохион байгуулжээ. Хэрэгжилт-86%</p>	
	Үр дүн.2-ийн хэрэгжилт: 84,0% (82+86)/2	

3. Борлуулалтын сүлжээг сайжруулах зорилтын хүрээнд:	
<p>Үр дүн 3.1. Хүнсэн дэх төмсний үүрэг</p>	<p>Үр дүн 3.1-ийн хүрээнд: 2009 онд төмс тариалагч гол бүс болох Төв, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Орхон зэрэг 5 аймгийн 13 сумын 320 өрхийг хамарсан суурь судалгааг хийснээр, тариалангийн бүс нутагт оршин суудаг иргэд нь бусад нутгийнханыг бодвол төмс илүү хэрэглэдэг ба үрийн төмсний талаар илүү мэдлэгтэй байдаг гэсэн таамаглалыг зөв болохыг баталж байна. Судалгаанд хамрагдагсдын 70% нь Голланд, Герман сортыг “Амт сайтай, тэжээллэг” гэж үзсэн бөгөөд дахин боловсруулсан бүтээгдэхүүн хэрэглэх сонирхол байдаг гэсэн нь хатаасан төмсний зах зээл байгааг харуулж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-75%</p>
<p>Үр дүн 3.2. Борлуулалтын сүлжээг сайжруулах</p>	<p>Үр дүн 3.2-ийн хүрээнд: МТХ УБ хотын “Sky”, “Миний дэлгүүр” зэрэг томоохон сүлжээ дэлгүүрүүд, “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээнд урамшуулалт худалдааг зохион байгуулж, 8 тн төмс борлуулалт хийж, шинэ сортуудын талаар иргэдэд мэдээлэл хүргэсэн. Зах зээлийн сүлжээнд оролцогчдын семинар хийж, төмсний борлуулалтын сүлжээнд тулгарч буй бэрхшээл, түүнээс гарах арга замын талаар хэлэлцсэн.</p> <p>Төмс үйлдвэрлэгч компаниуд 1,3,5,15 кг-аар савлан хэрэглэгчдэд хүргэж байна. БЗД-ийн зооринд 1,4 сая төгийн хөрөнгө оруулалт хийж, 217 тн-ын 483ш модон чингэлэг, 1,5 тн-ын жин, сэрээт өргөгч, цахилгаан үүсгүүр зэргийг авч зоорины ашиглалтыг сайжруулжээ.УБ хот болон орон нутагт төмс тариалдаг иргэдэд ариутгасан 10кг-аар савласан нийт 14 тн төмсний үрийг 365 өрхийн тариаланчдад борлуулсан. 2008 оны 4-р улиралтай харьцуулахад 2009 оны мөн үед импортоор оруулж ирсэн төмсний хэмжээ 25%-иар буурчээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-90%</p>
Үр дүн:3-ийн хэрэгжилт: 82,5% (75+90)/2	
4. Зохистой бодлого,нөхцөл зорилтын хүрээнд:	
<p>Үр дүн 4.1.Зохицуулах хороог бэхжүүлж, төмсний үндэсний хороо болгон зохион байгуулах</p>	<p>Үр дүн 4.1-ийн хүрээнд: Хөтөлбөрийн зохицуулах хороог 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр өргөтгөв. Үүнд: Оролцогч талуудын төлөөллийг оролцуулснаар тэдэнд МТХ-ийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн үйл явцад ашиг сонирхол, хэрэгцээ шаардлага тусгуулах боломж бүрдэх юм.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-85%</p>
<p>Үр дүн 4.2. Тогтвортой МХШТФХ</p>	<p>Үр дүн 4.2-ын хүрээнд: 2008 онтой харьцуулахад МХШТФХолбооны үйл ажиллагааг сайжруулахад санхүүжилт төлөвлөгдөж, зохих арга хэмжээ авч ажиллажээ. НҮБ-ийн ХХААБ-аас зарласан “Хүнсний үнийн хөөрөгдөлд нэврэгдсэн эмзэг бүлгийн иргэдэд төмс, хүнсний ногооны үрээр дэмжлэг үзүүлэх” ТСР/MON3202 төсөлд 600 тн сайн чанарын үр нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт дээрх холбоо шалгарч 11 аймаг, 9 дүүргийн 8000 өрхөд өөрийн тээврээр хүргэн өгч, чанарын өндөр үзүүлэлттэйгээр</p>

	<p>Үр дүн 4.3. Зээл орлогын боломж</p>	<p>нийлүүлсэн. Холбооноос Атрын 50 жилийн баярын арга хэмжээг зохион байгуулж, ЭШ-ний бага хуралд 6 илтгэл тавьж, төмсний салбарын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсэн нь судлаачид, үйлдвэрлэгчдийн талархлыг хүлээжээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-80%</p> <p>Үр дүн 4.3-ын хүрээнд: МХШТФХ-ны дэргэд Эргэлтийн санг үүсгэн зохион байгуулж, үйл ажиллагааны дүрэм, хөтөлбөрийг боловсруулсан. 15 фермерүүдийг зээлийн төсөл боловсруулах сургалтад хамруулж, үүнээс 7 фермер шалгарч 9 сая.төг-ийн хөнгөлөлттэй зээл олгогдсон. Зээл нь 100% эргэн төлөгдөх нөхцөлтэй болно.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт:70%</p>
<p>Үр дүн:4-ийн хэрэгжилт: 78,3% (85+80+70)/2</p>		
11	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	
<p>- МУЗГ-аас хэрэгжүүлж буй “Атрын-III дахь аян” тариалангийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн 2 дахь жил 2009 онд: Төмсний үйлдвэрлэл-28,5 мян.тн-оор, хүнсний ногооны үйлдвэрлэл-1,5 мян.тн-оор тус тус нэмэгдсэн. Монгол Улс дотоодын үйлдвэрлэлээр төмсний хэрэгцээгээ-100%, хүнсний ногооны хэрэгцээний 49%-ийг хангах боломжтой болсон.</p> <p>- 2009 онд улсын хэмжээнд 13000 гаруй га-д төмс тариалсны 10 гаруй хувьд нь хөтөлбөрөөс нутагшуулсан шинэ сортууд тариалагдсан байна. 2009 онтой харьцуулахад тариалсан талбайн хэмжээ 18,0%-иар, хураасан ургацын хэмжээ 2,0 дахин нэмэгджээ. 1га-аас авах ургац 20-45 тн/га байгаа нь улсын дунджаас 1,9 дахин өндөр байна.</p> <p>- Халаалтын систем бүхий шилэн хүлэмжид угсарсан аэропоник системээс 114,8 мян.ш бэсрэг булцуу хурааж авсан нь 2005 онтой харьцуулахад 3,8 дахин, 2008 оноос 12,0 мян.ш-ээр илүү үйлдвэрлэсэн байна. Бэсрэг булцууны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, гарцыг сайжруулснаар өөрийн өртөг 2007 онд 250 төгрөг байсан бол 2009 онд 69 төгрөг болж буурчээ. Монгол Улс энэхүү дэвшилтэт аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр Азид эхний тавд багтаж байгаа юм.</p> <p>- 2009 онд үрийн төмсний нийт 323,2 га талбайд улсын хянан баталгаа хийсэн нь 2008 оноос 74,2%-иар нэмэгдэж, 96,2 % нь сортын тариаланд тэнцжээ.МТХ нь импала сортын 374 тн элит, витара-150 тн элит,санте-700 гаруй тн 1-р репродукцийн үрийн нөөц бүрдүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд амжилттай хэрэгжүүлсэн үйл ажиллагааны нэг нь хөдөө орон нутгийн фермерүүдэд шинэ төрлийн пестицидийг туршин импортоор оруулж ирэх зөвшөөрөлтэй химийн бодисын жасаалтад оруулсан явдал юм. 2008 оны 4-р улиралтай 2009 оны мөн үеийг харьцуулахад импортоор оруулж ирж буй төмсний хэмжээ 25%-иар буурчээ. Хот суурин газрын зах зээлд төмс их хэмжээтэй борлуулагдаж байгаа учраас фермерүүд хураасан төмсөө хөдөө орон нутагт борлууллах болсонтой холбогдож хөдөөгийн хүн амын төмсний хэрэглээ нэмэгдсэн. Мөн иргэд өөрийн орны хөрсөнд ургасан цэвэр эрүүл хүнсний ногоог хэрэглэх болсон нь жилээм жилд харагдаж байна.</p> <p>2-р үе шатанд хөтөлбөрийн зорилтын арга хэмжээнүүдийн хэрэгжилт 2009 оны жилийн эцсийн байдлаар: Дунджаар 81,4 % буюу “Хангалттай” гэсэн үнэлгээг өгч байна.</p>		
<p>Дутагдал:</p>		
<p>-2009 онд нийт 5 сумаас хөрсний дээж аван шинжилсэн боловч, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд нематодын шинжилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж дутагдалтай байгаагаас шалтгаалж нематодыг тодорхойлж чадаагүй байна. Бэсрэг булцуу үйлдвэрлэлийн үе шатанд цагаан далавчтан шинээр нэмэгдэж вирус тараагчаар тодорхойлогдсон.Иймд хүлэмжийн болон аэропоникийн нөхцөлд вирусээс эрүүлжигдсэн бэсрэг булцуу үйлдвэрлэхэд хортон шавьжтай тэмцэх хяналтыг сайжруулах шаардлагатай байна.</p>		

	<p>- Аэропоникийг бүрэн хүчин чадлаар нь ашиглах:</p> <ul style="list-style-type: none"> ✓ УГТСЭШХ-2880 ургамал тарьж, 172800 ш бэсрэг булцуу хураах боломжтой. ✓ УХЭШХ-2304 ургамал тарьж, 138240 ш бэсрэг булцуу хураах боломжтой. 	
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	Хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна.
13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж	<ol style="list-style-type: none"> 1. Судалгаанд оролцох фермерүүдэд ажиглалт, судалгаа, туршилтын ажлын арга зүй эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах. 2. Орон нутгийн нөхцөлд төмсний зоорь барихдаа стандартын шаардлагыг хангах, дулаалга болон салхилуулалтын төхөөрөмжөөр тоноглох. 3. Үр үйлдвэрлэгчдийн үрийн шинэчлэлийг сайжруулах. 4. Төмсний үйлдвэрлэлийг хөдөө орон нутагт тасралтгүй нэмэгдүүлэх, зах зээлийн нөхцөлийг сайжруулах, шинэ технологийг алслагдсан бүс нутгуудад хөгжүүлэх. 5. Халаалтын системийн найдвартай ажиллагааг хангах . 6. Хугацаа хэтэрсэн 29,863,000₮-ийг зээлийн эргэлтийн санд төвлөрүүлэх.

CHF-Швейцарь франк

МХШТФХ-Монголын Хөдөөг Шинэчлэхийн Төлөө Фермерүүдийн Холбоо

АҮҮ-Албан үр үржүүлэгч

АБҮҮ-Албан бус үр үржүүлэгч

МТХ-Монгол төмс хөтөлбөр

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА